



ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2018 оны 08 сарын 07 өдөр

Дугаар А/АБ7

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай


Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэний нисэхийн ерөнхий газрын хэрэгцээнд шаардлагатай принтерийн хор, бичгийн цаас нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны дарга:	Б.Хоролбат	Санхүү, хөрөнгө оруулалтын газрын менежер
Нарийн бичгийн дарга:	Б.Санчир	Худалдан авах ажиллагааны тасгийн мэргэжилтэн
Гишүүд:	Б.Энх-Амгалан	Төсөл, хөтөлбөрийн хэлтсийн ахлах мэргэжилтэн
	Н.Жавхлан	"Чингис хаан" Олон улсын нисэх буудлын Үйлдвэрчний эвлэлийн хорооны төлөөлөл
	С.Чинзориг	Үйлдвэрчний эвлэлийн хорооны төлөөлөл

2. Нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Үнэлгээний хороо /Б.Хоролбат/-нд даалгасугай.

3. Тендер болон сонгон шалгаруулалттай холбогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөх, Тендер нээхэд үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг гаргуулан Дотоод аудитын албанд хүргүүлэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга /Б.Санчир/-д үүрэг болгосугай.



Л.БЯМБАСҮРЭН